



Н.ГАНТУЛГА
ХСИС-ийн
Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн захирал,
хууль зүйн доктор,
профессор, хурандаа

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН “ҮНДСЭН ХУУЛЬД” ОРСОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

“Хүний эрх” гэсэн нэр томъёо манай орны төрийн бодлогын баримт бичиг ², хууль зүйн практикт хэрэглэгдэн хэвшсээр цөөнгүй жил болж байна.

Хэдийгээр Монгол Улс хүний эрхийн олон улсын тулгуур баримт бичгүүдэд ³ бүр 1970-аад оноос нэгдэн орсон боловч нийгмийн тогтолцоо, хөгжил, хүний эрхийн асуудалд хандах үзэл суртлын ялгаатай байдлаас шалтгаалан олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг тэр бүр бүрэн дүүрэн хэрэгжүүлэлгүй явж ирсэн. Тухайлбал: хөдлөх, үл хөдлөх эд

хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах, өмчлөгчийн эрхийн адил тэгш байдлыг хангах, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эсрэг чиглэсэн мэдүүлэг өгөхгүй байх, эх орноо орхин явах зэрэг эрх үүнд юуны өмнө хамаарна.

Олон улсын гэрээний актууд хамрах хүрээ, агуулга, олон улсын зан заншлын хэм хэмжээтэй уялдан гэрээ, хэлэлцээр, конвенц, пакт, протокол, дүрэм (журам), үр дүнгийн баримт бичиг (төгсгөлийн баримт бичиг), тунхаглал, санамж бичиг гэсэн янз бүрийн нэртэй байхын зэрэгцээ хууль зүйн үр дагаварын хувьд ч хэм хэмжээ тогтоосон эсвэл зөвлөмж-удирдамж өгсөн хэмээн хуваагддаг.

Мөн хүний эрхийн олон улсын гэрээний тогтолцоонд хорих ял, түүнийг эдлүүлэхтэй холбоотой олон улсын гэрээний актууд онцгой байр эзэлдэг. Учир нь эдгээр баримт бичигт хууль зүйн дагуу хүний ямар эрхийг, хэзээ, хэрхэн, хэн, ямар хэмжээнд хасч, хязгаарлаж болох, эсэх асуудал бэхжсэн байдаг.

Тэгвэл энэ салбарын “Хоригдлуудтой харьцах НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд”⁴ нь

¹ “Үндсэн хууль” гэсэн нэр томъёог хашилтад хэрэглэсэн ба хорих ял эдлүүлэх эрх зүйд “Хоригдлуудтай харьцах НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд”-ийг дэлхий дахинаа энэ салбарын суурь баримт бичиг хэмээн удирдлага болгон хэрэглэж байгаа олон улсын практикийг иш үндэс болгосон.

² Хууль тогтоомж, эрх зүйн дэд акт гэсэн агуулгаар хэрэглэсэн.

³ Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт зэрэг бусад

⁴ Энэ баримт бичгийг Монгол Улсад хүний эрхийн асуудлаар хэрэгжүүлж буй төслийн хүрээнд НҮБ-ын Хүний эрхийн төв, Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчид орчуулж, П.Эрдэнэбаяр хянан

хэдийгээр хэлбэрийн хувьд хууль зүйн заавал биелүүлэх үүргийг хүлээлгээгүй боловч түүнийг улс гүрнүүд “дэлхий дахинаа заавал хангах ёстой ерөнхий стандарт” буюу энэ салбарын тулгуур баримт бичиг (“Үндсэн хууль”) хэмээн үнэлж хэрэгжүүлэх практик нэгэнт тогтжээ.

Иймд эрх зүйн энэ баримт бичиг, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтүүд, тэдгээрийг мэдээлэх, хэрэгжүүлэх чиглэлд манай орны хувьд нэн тэргүүнд хийвэл зохих арга хэмжээтэй холбоотой судлаачийн зарим саналыг холбогдох эрх бүхий байгууллага, иргэний нийгэмд хүргэх зорилгоор эрдэм шинжилгээний нийтлэл (өгүүлэл)-ийг бичиж агуулгыг нь тодорхойлсон.

тохиолдуулан анх “Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дах хүний эрх” /УБ.1996 он/ эмхэтгэлд, мөн Д.Баярсайхан /Ph.D/, Т.Золбоо /LL.M/ нар “Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл”-д /УБ.2012 он/, түүнчлэн Хүний эрхийн үндэсний комисс “Монголын хорих байгууллагуудад хүний эрх болон ардчиллыг хөгжүүлэх, иргэний нийгмийг дэмжих төсөл”-ийн хүрээнд Европын холбоо, Чехийн хөгжлийн агентлагын санхүүжилтээр “Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл /хорих байгууллагын ажилтнуудад зориулсан, УБ.2014 он/-д тус тус монгол хэлээр хөрвүүлэн нийтэлсэн.

Баримт бичгийн нэр англи хэлнээ “*Standard Minimum Rules for the Treatment of Prisoners*”, орос хэлнээ “*Минимальные стандартные правила обращения с заключенными*” гэж бичигддэг. [//www.un.org/ru](http://www.un.org/ru)

I

Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд⁵ бүтцийн хувьд удиртгал, хавсралтын 1-р хэсэг “Нийтлэг хэрэглэх дүрмүүд”, 2-р хэсэг “Онцлог бүлгийнхэнд хэрэглэх дүрмүүд” бүхий 95 зүйлээс бүрдэж байсан.

Харин НҮБ-ын жишиг дүрмүүдийг баталсан 1955 оноос хойш олон улсын эрх зүй, ял эдлүүлэх эрх зүйн шинжлэх ухаан, дэлхийн улс гүрнүүдийн хууль зүйн практикт гарсан ололт дэвшил, өөрчлөлттэй уялдуулан нэмэлт өөрчлөлтөөр баяжуулан засварлах асуудал хэлэлцэгдэх болж улмаар НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2011 онд асуудлыг судлан төсөл боловсруулах Засгийн газар хоорондын нээлттэй бүрэлдэхүүнтэй шинжээчтэй баг байгуулах шийдвэр гарган энэ үйл хэрэгт НҮБ-ын бусад байгууллага, иргэний нийгмийг анхаарал хандуулан хувь нэмэр оруулахыг уриалсан.

Шинжээчдийн баг 2012-2014 онуудад НҮБ-ын Мансууруулах

⁵Энэ баримт бичгийг НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд гэж товчлон хэрэглэх олон улсын практик бий ба түүнийг 1955 онд Женев хотноо хуралдсан НҮБ-ын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгчдэд хандах асуудлаарх 1-р их хурлаар баталж, НҮБ-ын Эдийн засаг, Нийгмийн зөвлөлийн 1957 оны 663 С(XXIY), 1977 оны 2076 (LXII) тогтоолоор сайшаасан. [//www.un.org/ru](http://www.un.org/ru)

бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн албаны ⁶ идэвхитэй оролцоо, хамтын ажиллагааны дүнд 3 удаагийн зөвлөлдөх уулзалтын явцад дүрмийг хянаж өөрчлөхөд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн удирдамж болгон зөвлөсөн:

-а/ үйлчилж буй жишиг дүрмийн шаардлагыг бууруулахгүй байх, хоригдлын аюулгүй байдлыг хангах, тэдэнтэй харьцах хүмүүнлэг нөхцлийг нэмэгдүүлэх,

-б/ дүрмийг хэрэглэж байгаа практик түвшинг дэмжих чиглэлийг баримтлан ихээхэн амжилтад хүрч өөрчлөлт оруулах асуудлын хүрээг тодорхойлж чадсан.

Мөн 2015 оны 03-р сард Өмнөд Африкийн Кейптаунд зохион байгуулсан шинжээчдийн 4 дэх зөвлөлдөх уулзалтын үр дүнд “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд”-д нэмэлт өөрчлөлт оруулах бүх асуудлаар нэгдсэн зөвшилд хүрсэний гадна хүний эрх, тэгш байдал, ардчилалын төлөө тэмцэгч, 27 жил шоронд хоригдож байсан, Өмнөд Африкийн Бүгд найрамдах Улсын ерөнхийлөгч асан Нельсон Ролилахлы Манделаг хүндэтгэж, илэрхийлэл нь болгон энэ дүрмийг

“Манделагийн дүрмүүд” гэж нэрлэхийг уриалсан.

Тэрчлэн Нельсон Манделагийн олон улсын өдрийг⁷ шоронд хорих нөхцлийг улам бүр хүмүүнлэг болгох, хоригдлууд нийгмийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг ба хорих байгууллагын алба хаагчдын ажил үүрэг онцгой ач холбогдол бүхий нийгмийн ажил болохыг нийтэд улам бүр түгээн мэдээлэхэд илүү үр дүн өгсөн өдөр болгон өргөжүүлэхийг зөвлөсөн.

НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн эрх зүйн асуудал эрхэлсэн комисс болон НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл 2015 оны 05-р сард шинжээчдийн багийн төслийг хэлэлцэн дэмжиж улмаар НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2015 оны 12-р сарын 17-ны өдрийн 70/175 тогтоолоор “Хоригдлуудтай харьцах НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд ⁸”-ийн нэмэлт өөрчлөлтийг баталсан.

II

Хоригдлуудтай харьцах НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийн өөрчлөлт нь эрх зүйн энэ баримт бичгийн 35 орчим хувийг хамарсан ба тэдгээрийг дараах 9 сэдэвчилсэн чиглэлд хувааж болно. Энэ нь:

⁶ Орос хэлнээ “Управление ООН по наркотикам и преступности /УНП ООН/”, англи хэлнээ United Nations office on drugs and crime /UNODC/ www.unodc.org/

⁷ 07-р сарын 18-ны өдөр

⁸ НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийг “Нельсон Манделагийн дүрмүүд” гэж нэрлэхээр тогтсон.

1/ Хоригдлын хүний эрхэм чанарыг хүндэтгэх

2/ Эрх чөлөө нь хасагдсан эмзэг бүлгүүд

3/ Эмнэлгийн үйлчилгээ, эрүүл мэндийн хамгаалал

4/ Хязгаарлалт, сахилга дэг журам, шийтгэлийн арга хэмжээ

5/ Хорих газар дахь нас баралт, эрүү шүүлтийн мөрдөн шалгах ажиллагаа

6/ Хууль зүйн туслалцааны нээлттэй байдал

7/ Гомдол хүсэлт, хараат бус шалгалт

8/ Нэр томьёо

9/ Алба хаагчдын сургалт тус тус болно.

Манделагийн дүрмүүд⁹ одоо удиртгал болон хавсралт, түүний 4 урьдчилсан тэмдэглэх хэсэг ба нийт 122 дүрмээс бүрдэж байна. Тодруулбал:

Нэг. Хоригдлын хүний эрхэм чанарыг хүндэтгэх

Энэ асуудал НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийн 1-5 дүрэмд тусгалаа олсон. Бүх хоригдолд хэрэглэх дүрмийн I-р хэсэг нийт жишиг дүрмүүдийг ойлгож хэрэглэх 5 “үндсэн зарчим” бүхий өргөтгөсөн стандартыг хамрах болсон.

Хуучин дүрмийн II А хэсгийн хорих ял эдлэгчидтэй холбоотой томъёолалууд эдгээр 5 зарчимд нэгтгэгдсэний зэрэгцээ энэ зарчмын агуулгад олон улсын эрх зүйн салбарын амжилтууд ч туссан. Тухайлбал, энэ зарчмууд дараах үүргүүдийг хүлээлгэсэн. Энэ нь:

-Хоригдол бүр эрхэм чанар бүхий бие хүн болохын хувьд хүндэтгэлтэй харьцаанд байх ёстой.

-Хоригдлууд эрүүдэн шүүх болон бусад хүнлэг бус харьцаанаас ангид, хамгаалагдсан байна.

-Хоригдлууд, албан хаагчид, хорих газар байгаа бусад хүмүүсийн байнгын хамгаалал, аюулгүй байдал хангагдсан байх ёстой.

Хоёр. Эрх чөлөө нь хасагдсан эмзэг бүлгүүд

НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийн 2, 5(2), 39(3), 55(2), 109, 110 дүрэмд энэ асуудал туссан.

Алагчлалгүй хэрэглэх, яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл, үндэсний ба нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, язгуур гарлаар ялгаварлан гадуурхахыг хориглосон “Наад захын жишиг дүрмүүд”-ийн хуучин заалт “бусад ямар ч үндэслэлээр” гэсэн

⁹ Энэ баримт бичгийг мөн “НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд” нэрээр хэрэглэж болно.

нэмэлтээр өргөжсөний зэрэгцээ хоригдлын шашны болон ёс зүйн итгэл үнэмшлийг хүндэтгэхийг үүрэг болгосон.

Ер нь үл ялгаварлан гадуурхах зарчим дараах үүргийг агуулгадаа багтаан туссан. Энэ нь:

-Хоригдлын, тэр дотроо эмзэг бүлгийнхний хувь хүний онцлог хэрэгцээг харгалзах;

-Онцлог хэрэгцээ бүхий хоригдлын эрхийг хангахад чиглэсэн арга хэмжээг авах;

-Бие махбодь, оюун санаа, бусад байдлаар бэрхшээлтэй хоригдлын эрүүл мэндийн байдлыг харгалзан хорих газраас үзүүлдэг үйлчилгээнд бусадтай адил байдлаар бүрэн, үр дүнтэй хамрагдах нөхцлийг хангах ёстой.

Гурав. Эмнэлгийн үйлчилгээ, эрүүл мэндийн хамгаалал

НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийн 24-27, 29-35 дүрэмд хоригдолд эмнэлэг-эрүүл ахуйн үйлчилгээ үзүүлэх нь төрийн үүрэг ба хоригдлууд эмнэлэг-эрүүл ахуйн үйлчилгээнд жирийн иргэдийн адил нэг стандартын хүрээнд хамрагдахыг тодотгосны зэрэгцээ хорих газарт үзүүлэх эмнэлэг-эрүүл ахуйн үйлчилгээний хэмжээ, бүрэлдхүүн хэсгийг заасан нэмэлт өөрчлөлтөөр баяжсан.

Түүнчлэн эмнэлгийн ажилтны эрх, үүргийг тодорхойлсон заалт нь эмч,

эмнэлгийн бусад мэргэжилтнүүд ба хоригдол хоорондын харилцаа иргэний нийгэмд өвчтнүүдэд хэрэглэгддэг ёс зүй, мэргэжилийн адил стандартаар зохицуулагдахаар тодотгогдон бэхжсэн. Тухайлбал: эдгээр заалт нь дараах үүргийг өөртөө агуулсан. Энэ нь:

-Нийгэмд үйлчилж байгаа эмнэлэг-эрүүл ахуйн үйлчилгээний адил стандарт, тэр дотроо төлбөргүй үйлчилгээ аливаа ялгаваргүйгээр хорих газарт хэрэгжих;

-Хоригдлын, ялангуяа онцлог хэрэгцээ бүхий хоригдлын бие махбод, сэтгэцийн байдлыг үнэлэх, дэмжих, хамгаалах, сайжруулахад онцгой анхаарал хандуулах;

-Эмнэлгийн хараат бус байдал, эмчийн нууц, зөвшөөрснөөр мэдээлэх “эмч-өвчтөний харьцааны” болон эмчилгээг тасралтгүй үргэлжлүүлэх (ДОХ, сүрьеэ, нийгмийн бусад халдварт өвчин, мансуурах донг хамруулан), сувилах зарчмуудыг чанд сахих;

-Эрүүдэн шүүх болон бусад хүнлэг бус хэлбэрээр харьцах идэвхитэй болон идэвхитэй бус бүх төрлийн үйл ажиллагаанд эмнэлгийн ажилтнууд оролцохыг бүрэн хориглож, харин тийм үйл ажиллагааг баримтжуулж, мэдээлэх үүргийг тэдэнд дүрмийн нэмэлт өөрчлөлтөөр хүлээлгэсэн.

Дөрөв. Хязгаарлалт, сахилга дэг журам, шийтгэлийн арга хэмжээ

Жишиг дүрмүүдийн 36-39, 42-53 дүрэмд хоригдлын эрхийг хязгаарлах болон эрүүдэн шүүх, хүнлэг бус шинжтэй сахилгын шийтгэлийн шалгуур, үнэлгээний асуудал туссан.

Түүнчлэн сахилгын шийтгэлийн журмаар хоригдлыг хорих нийтлэг нөхцөл, хоригдлын мэдээлэл авах, танилцах эрх болон хоригдлыг ганцаарчлан хорьж сахилгын шийтгэл хүлээлгэх, номхруулах хэрэгсэл хэрэглэх явдлыг хязгаарласан, мөн хорих өрөө, хоригдлыг нэгжих үйл ажиллагааг зохицуулсан, эмнэлгийн ажилтнуудын сахилгын зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаан дах үүрэг, оролцоог нэмэлт өөрчлөлтөөр тодотгосон. Тухайлбал, Шинэ дүрмүүд нь дараах зохицуулалтыг бий болгосон. Энэ нь:

-Нэг өдөрт хүмүүстэй харьцуулахгүйгээр 22 цаг ба түүнээс дээш хугацаагаар ганцаарчлан хорих нь (мөн энэ үйл ажиллагаа тасралтгүй 15 хоногийн турш үргэлжилбэл удаан хугацаагаар ганцаарчлан хорьсон гэж үзнэ) хоригдлын эрх чөлөөг хязгаарласанд тооцох¹⁰ ба түүнийг онцгой тохиолдолд “тусгай” арга хэмжээ болгон хэрэглэнэ.

-Тодорхой бус хугацаагаар эсвэл удаан хугацаагаар ганцаарчлан хорих, гэрэлгүй харанхуйд эсвэл байнгын гэрэлтүүлэг бүхий өрөөнд хорих, хоол хүнс, ундны усны хувь хэмжээг багасгах, тэрчлэн мөн чанарын хувьд хүний эрхэм чанарыг гутаан доромжилсон, тэдэнд өвдөлт шаналгаа учруулагч, жишээбэл, дөнгө, гинж зэрэг номхруулах хэрэгслийг хэрэглэхийг хориглоно¹¹.

-Хоригдол, тэдний өрөө тасалгаанд нэгжлэг хийх, хорих байгууллагад аюулгүй байдлыг хангах зорилгоор тусгай хэрэгслүүдийг ашиглахтай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний бусад актын шаардлагыг биелүүлэх нарийвчлан журамласан удирдамжийг боловсруулах, энэ бүх тохиолдолд хоригдлын хүний эрхэм чанарыг хүндэтгэнэ.

-Эмнэлгийн ажилтнууд аливаа хэлбэрээр албадан тусгаарлагдсан хоригдлын эрүүл мэндэд онцгой анхаарал хандуулах үүрэгтэй ба тэдэнд сахилгын шийтгэл хүлээлгэхэд оролцох ёсгүй.

-Зөрчилдөөнт нөхцөл байдлыг урьдчилан сэргийлэх, түүнийг бий болсон тохиолдолд шийдвэрлэх, зуучлагч оролцуулах

¹⁰ НҮБ-ын наад захын жишиг дүрмийн 44 дүрэм.

¹¹ НҮБ-ын наад захын жишиг дүрмийн 43, 47 дүрэм

болон зохицуулалтын бусад сонгох механизмыг өргөн ашиглах хорих байгууллагын захиргааны үйл ажиллагааг урамшуулан дэмжих заалт тус тус болно.

Тав. Хорих газар дахь нас баралт, эрүү шүүлтийн мөрдөн шалгах ажиллагаа

НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийн 6-10, 68-72 дүрэмд туссан. Энэ асуудлаар орсон өөрчлөлтийн гол агуулга нь хорих газарт нас барсан болон бусад ноцтой нөхцөл байдлын тохиолдол бүрт хараат бус мөрдөн шалгах үйл ажиллагааг явуулах зохицуулалт юм.

Мөн харилцааны нээлттэй /тодорхой/, хариуцлагатай байдлыг хангах зорилгоор хорих газарт бүртгэн хөтөлдөг ялтны мэдээллийн жагсаалт, түүнчлэн ноцтой үр дагавар бүхий нөхцөл байдлын талаар хорих газрын захиргаанаас хоригдлууд, хараат бус этгээдүүдэд өгөх мэдээллийн жагсаалт ч өргөжсөн. Тухайлбал:

Дүрмийн өөрчлөлтүүд нь дараах асуудлыг хамарсан. Энэ нь:

-Хоригдлын хорих газарт ирсэнээс эхлээд хоригдох бүх хугацааны мэдээлэл тэдний хувийн хэрэгт тусах ёстой ба мэдээллийн нууцлал задрахгүй байх явдлыг хорих газрын захиргаа бүрэн хангах ёстой.

-Хоригдол, бусад холбогдох хүмүүс (гэр бүлийн холбоотой хүмүүс) түүнийг хаана хорьж байгаа болон шилжин очсон хорих газар, хүндээр өвчилсөн тухайгаа, мөн биедээ гэмтэл авсан, хоригдогч нас барсан талаарх мэдээллийг нэн даруй хүргэх, авах эрхтэй.

-Хорих газрын захиргаа хоригдол нас барсан, алга болсон, хоригдох хугацаанд биедээ хүнд гэмтэл авсан тохиолдол бүрт зохих мэдээллийг нэн даруй хараат бусаар тухайн үйл явдал, түүний шалтгааныг шуурхай, алагчлалгүй, үр дүнтэй мөрдөн шалгах эрх бүхий байгууллагад хүргэх ёстой.

-Хоригдлыг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бусаар хатуу ширүүн харьцсан тохиолдол бүрт албан ёсоор гомдол хүсэлт гаргасанаас үл шалтгаалан мөрдөн шалгах ажиллагааг явуулах ёстой.

Зургаа. Хууль зүйн туслацааны нээлттэй байдал

НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийн 41, 54-55, 58-61, 119-120 дүрэмд энэ асуудал туссан.

Өмгөөлөгчийн хорих газарт байгаа үйлчлүүлэгч-хоригдолтой уулзах, мөн хоригдлын зөвлөгөө авах эрх НҮБ-ын жишиг дүрмүүдийн өөрчлөлтөөс өмнө зөвхөн мөрдөн шалгагдаж байгаа хоригдогчийн эрхийг хамгаалах

хүрээнд хамаарч байсан бол одоо бүх хоригдолд үйлчлэх болсны зэрэгцээ сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх явцад ч хоригдол хууль зүйн зөвлөгөө авах эрхтэй болсон.

Мөн дүрмийн өөрчлөлт нь хорих газарт нэвтрэн орж байгаа хүмүүс нэгжлэг хийх, мэдээлэл авах боломж, процедурын талаархи мэдээллийг авахаар туссан. Тухайлбал: хорих газрын захиргаа дараах үүргийг хүлээнэ. Энэ нь:

-Хорих газарт хоригдол ирснээр түүнд хууль зүйн зөвлөгөө-тусламж авах асуудлаарх мэдээллийг бичгээр нэн даруй өгөх ёстой.

-Хоригдолд өөрийн сонголтоор өмгөөлөгчтэй болон хууль зүйн туслалцаа үзүүлэх бусад хүнтэй уулзах хугацаа, нөхцлийг аливаа хүнд сурталгүйгээр, мэдээлэлд нь цензур тавилгүй, нууцлалыг нь бүрэн хангасан нөхцөлд явуулах зохих боломжоор хангах ёстой.

-Хоригдол өөрийгөө өмгөөлөх, хууль эрх зүйн туслалцаа авах эрхийг ялангуяа мөрдөн шалгах үйл ажиллагааны, тэр дотроо сахилгын ноцтой зөрчилд буруутгаж байгаа тохиолдолд олгох ёстой.

-Хорих өрөө болон хоригдолд хийх процедуртай адил журмаар хийх үзлэг нь нэр хүндэд нь халдах, зохих хэмжээнд

хамгаалагдаагүй гэж тооцон татгалзвал тухайн хүнд үзлэг хийх, хорих газарт нэвтрүүлэхээс татгалзана.

Долоо. Гомдол хүсэлт, хараат бус шалгалт

НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийн 54-57, 83-85 дүрэмд туссан. Шинэчлэгдсэн дүрмүүд нь хоригдол, тэдгээрийн өмгөөлөгчид тэдэнтэй харьцсан асуудлаарх гомдол хүсэлтийг саадгүй гаргах эрх болон хорих газрын захиргаа гомдол хүсэлтийг даруй хэлэлцэн шалгаж, хариуг өгөх явдлыг бэхжүүлсэн.

Мониторинг болон хянан шалгах салбарт хүрсэн томоохон ололт нь хорих газар, хорих байгууллагыг тогтмол хянан шалгах дотоодын болон гадны хоёрдмол тогтолцоо бүхий механизмыг бий болгосон явдал мөн. Тухайлбал, шинэ дүрмүүд дараах журмыг тогтоосон. Энэ нь:

-Хоригдол, түүний өмгөөлөгч гомдол хүсэлт гаргах эрхээ хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд хоригдогчийн гэр бүлийн гишүүд, мөн нөхцөл байдлыг мэдсэн хэн ч тухайн асуудлаар гомдол хүсэлт гаргах эрхтэй.

-Хэрвээ гомдол хүсэлт гаргагч, түүний энэ үйл ажиллагаа ямар нэгэн өс хонзон, айлган сүрдүүлэлт, бусад сөрөг

нөлөөллөөс ангид, аюулгүй, нууцлалыг хангасан түвшинд явагдахыг хүсч хандвал хэрэгжих баталгааг хорих газрын захиргаа хангах ёстой.

-Хорих газар, хорих байгууллагын үйл ажиллагааг тогтмол хянан шалгах хоёрдмол тогтолцоог бүрдүүлэх ёстой ба энэ нь хорих газрыг удирдах төв байгууллагаас явуулах дотоодын, мөн хорих газрын захиргаанаас ангид, хараат бус байгууллагаас явуулах гадны хяналт шалгалт болно.

-Хянан шалгах эрх бүхий ажилтнуудад өөрийн үүргийг бүрэн дүүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь зориулан хорих газрын бүх мэдээлэлтэй танилцах, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг өөрийн санаачлагаар хийх, нууцлалыг хангасан түвшинд хоригдол, хорих газрын ажилтнуудтай уулзах эрхийг олгох ёстой.

Найм. Нэр томьёо

НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд дэх нэр томьёоны шинэчлэл нь олон улсын эрх зүйн салбарт гарсан өөрчлөлттэй холбоотой ба эмнэлэг-эрүүл ахуй, жендерын болон уламжлалт бус эрхийн асуудалтай холбогдсон.

Ес. Алба хаагчдын сургалт

НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийн 76-76 дүрэмд тусгалаа олсон. Шинэ дүрмүүд нь иргэдийг ажилд авахад орон нутгийн нөхцөлд дасан зохицох сургалтад хамруулах, мөн алба хаагчдаас алба хаах явцад тэдэнд хүлээлгэсэн нарийн төвөгтэй үүргүүдийг бүрэн дүүрэн, хуулийн хүрээнд хэрэгжүүлэх боломж, хэрэгслээр хангасан нөхцөлд зохион байгуулагдахыг бэхжүүлж өгсөн. Түүнчлэн сургалтын анхны /удиртгал/ хичээлүүд нь оролцогчдын онол, практикийн мэдлэгийг шалгасан дараах сэдвийг зайлшгүй хамрах ёстой. Энэ нь:

-Холбогдох улс гүрний дотоодын хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний акт төрийн бодлого, тэрчлэн хорих байгууллагын алба хаагчийн үйл ажиллагаа, хоригдлуудтай харьцахдаа удирдлага болгон хэрэгжүүлэх олон улсын ба бүс нутгийн эрх зүйн баримт бичиг;

-Хоригдол бүрийн хүний эрхэм чанарыг хүндэтгэх, тэдэнтэй хүнлэг бус, хэрцгий догшин харьцахыг хориглох зэрэг хорих байгууллагын алба хаагчдын чиг үүргээ хэрэгжүүлэхэд баримтлах эрх, үүрэг;

-Хамгаалах ба аюулгүй байдлыг хангах сургалт, мөн

тусгай хэрэгслийг тухайн нөхцөл байдалд нийцүүлэн хэрэглэх, хүч хэрэглэхийн өмнө боломжтой бүх тохиолдолд сануулга өгөх;

-Бусад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, сэтгэц-нийгэмшлийн шаардлагатай хоригдолд нийгмийн зохих туслалцаа, дэмжлэг үзүүлэх мэдлэг, ур чадвар, практик дадал эзэмших явдал болно.

Энэ бүгдэд үндэслэн Хоригдлуудтай харьцах НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд нь өнөө цаг үеийн эрх зүйн шинжлэх ухааны ололт амжилт, дэлхийн улс гүрнүүдийн шилдэг туршлагыг тодорхой түвшинд нэгтгэсэн салбарын тулгуур баримт бичиг болохыг дахин нотлохыг хүслээ.

Иймд судлаач эрх зүйн энэ баримт бичгийн талаархи мэдээллийг нийгэмд бодитой, бүрэн дүүрэн хүргэх зорилгоор нэн даруй дараах арга хэмжээг авах ёстойг санал болгож байна. Энэ нь:

1. Хоригдлуудтай харьцах НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийг нэмэлт өөрчлөлтийн хамт захиалгын үндсэн дээр мэргэшсэн орчуулагч, хуульчдын хамтын багаар хөрвүүлүүлэн, ГХЯ, ХЗДХЯ хянаж, хөрвүүлгийг англи,

2. орос хэлний ¹² бичвэрийн хамт хэвлэж ¹³ хууль тогтоох,

хэрэгжүүлэх болон сургалт, судалгааны бусад зорилгоор ашиглах практикийг тогтоох.

3. Шаардлагатай гэж үзвэл энэ жишиг дүрмүүдийг нийтэд хүргэхэд НҮБ-ын Мансуурах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн албанд (UNODC) хандан техникийн туслалцаа, бусад дэмжлэгийг авах.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад Хоригдлуудтай харьцах жишиг дүрмүүдийн холбогдох хэм хэмжээг /ялангуяа, хоригдлын эрхийн хязгаарлалт, тэдэнд шийтгэлийн арга хэмжээ ноогдуулах, гомдол хүсэлтийг нь хүлээн авах, хянан шийдвэрлэх, хууль зүйн туслалцаа авах, хорих байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих зэрэг/ тусгах шаардлага байна.

¹² НҮБ-ын албан ёсны хэл учир тэдгээр хөрвүүлгийн хамт хэвлэвэл олон талын ач холбогдолтой гэж үзэж байна.

¹³ Энэ цаг үе дэхь нийтийн хүрээнд байгаа мэдээлэл, судалгааны бусад эх сурвалжаас үзвэл “Хоригдлуудтай харьцах НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд”-ийн нэмэлт өөрчлөлтийн талаархи мэдээлэл манай оронд бараг байхгүй байна.